

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 7058-4204, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
---------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-12
3. Аудитын илрүүлэлт	11
5.1 Төлбөрийн акт.....	11
5.2 Албан шаардлага.....	12
5.3 Зөвлөмж.....	12
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ЗГ	Засгийн газар
СС	Сангийн сайдын
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.25 № 303

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР
БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.САЙХАНГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 4 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн тайланг аймгийн Засаг даргаас 98.1 хувиар дүгнэсэн байна.

011022151

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>282,903,273.53</u>	<u>294,611,893.90</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	12,939,186.00	469,938.37
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	469,938.37
335	Бусад авлага	12,939,186.00	-
33510	Байгууллагаас авах авлага	2,089,186.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	10,850,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	269,964,087.53	294,141,955.53
354	Хангамжийн материал	269,964,087.53	294,141,955.53
35410	Бичиг хэргийн материал	1,166,000.00	720,000.00
35420	Аж ахуйн материал	89,893,462.53	108,789,982.53
35430	Сэлбэг хэрэгсэл	-	5,500,000.00
35460	Хүнсний материал	-	227,348.00
35470	Бусад хангамжийн материал	178,904,625.00	178,904,625.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>651,600,675.36</u>	<u>705,266,553.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	651,600,675.36	705,266,553.56
392	Биет хөрөнгө	558,359,425.36	617,550,303.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	472,587,545.80	472,587,545.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,922,399.28)	(49,415,480.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,500,000.00	43,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,333,333.12)	(40,416,666.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,020,000.00	181,520,302.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,376,666.66)	(47,502,969.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,240,717.26	77,082,717.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,231,438.48)	(35,742,645.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,500,000.00	20,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,625,000.16)	(4,562,500.20)
393	Биет бус хөрөнгө	93,241,250.00	87,716,250.00
39301	Програм хангамж	9,600,000.00	11,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,600,000.00)	(9,800,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	93,810,000.00	93,810,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(568,750.00)	(7,393,750.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>934,503,948.89</u>	<u>999,878,447.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>(0.00)</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>934,503,948.89</u>	<u>999,878,447.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	934,503,948.89	999,878,447.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259,801,915.41	259,801,915.41
51101	Өмч: - төрийн	259,801,915.41	259,801,915.41
512	Хуримтлагдсан үр дүн	674,702,033.48	740,076,532.05
51210	Өмнөх үеийн үр дүн	274,463,503.23	661,891,057.89
51220	Тайлант үеийн үр дүн	400,238,530.25	78,185,474.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>934,503,948.89</u>	<u>999,878,447.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,280,826,338.83	2,269,089,993.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	482,263,679.83	122,010,362.00
120	Нийтлэг татварын бус орлого	482,263,679.83	122,010,362.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	421,036,372.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	421,036,372.00	-
120009	Бусад орлого	61,227,307.83	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	110,197,362.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	11,813,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	798,562,659.00	2,147,079,631.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	626,308,200.00	1,045,912,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	626,308,200.00	1,045,912,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172,254,459.00	1,101,167,531.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,706,029.00	772,691,104.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,548,430.00	328,476,426.30
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	880,587,808.58	2,163,154,518.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	880,587,808.58	2,163,154,518.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	813,601,344.45	2,062,830,722.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	356,108,973.99	506,154,360.88
210101	Үндсэн цалин	315,201,108.73	260,899,943.39
210102	Нэмэгдэл	31,079,564.57	168,165,027.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,793,000.00	55,692,500.00
210104	Урамшуулал	4,035,300.69	21,396,889.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,000,100.00	63,281,521.44
210201	Тэтгэврийн даатгал	36,080,833.12	36,442,451.86
210202	Тэтгэмжийн даатгал	3,387,544.90	5,211,376.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,411,735.91	8,495,691.73
210204	Ажилгүйдлийн даатгал	1,261,409.29	3,008,575.34
210205	Эрүүл мэндийн даатгал	5,858,576.78	10,123,425.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,159,366.34	7,647,267.63
210301	Гэрэл, цахилгаан	6,839,712.87	4,398,217.63
210302	Түлш, халаалт	6,627,833.47	2,070,530.00
210303	Цэвэр, бохир ус	691,820.00	1,178,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,014,120.00	16,639,140.00
210401	Бичиг хэрэг	259,380.00	826,320.00
210402	Тээвэр, шатахуун	383,800.00	3,325,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	370,940.00	353,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,091,040.00
210408	Бараа материал акталсны зардал	-	9,043,180.00
2105	Нормативт зардал	-	760,797.00
210502	Хоол, хүнс	-	760,797.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,500,000.00

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан			
210604	Урсгал засвар	-	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	487,100.00	-
210702	Дотоод албан томилолт	487,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	355,052,441.97	989,801,817.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	354,230,181.97	988,308,716.45
210803	Даатгалын үйлчилгээ	-	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,460.00	49,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	703,800.00	1,340,146.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,779,242.15	477,045,817.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	424,869,393.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,779,242.15	52,176,423.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,986,464.13	100,323,796.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,184,000.00	57,032,754.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	54,761,254.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,184,000.00	2,271,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,802,464.13	43,291,042.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,802,464.13	43,291,042.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	400,238,530.25	105,935,474.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	27,750,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	27,750,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(27,750,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	400,238,530.25	78,185,474.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	859,789,966.83	2,147,079,631.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,227,307.83	-
120	Нийтлэг татварын бус орлого	61,227,307.83	-
120009	Бусад орлого	61,227,307.83	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	798,562,659.00	2,147,079,631.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	626,308,200.00	1,045,912,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	626,308,200.00	1,045,912,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	172,254,459.00	1,101,167,531.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,706,029.00	772,691,104.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,548,430.00	328,476,426.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	859,789,966.83	2,147,079,631.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	859,789,966.83	2,147,079,631.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,803,502.70	2,046,755,834.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,892,823.99	508,160,466.89
210101	Үндсэн цалин	233,154,326.59	275,964,974.61

**Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210102	Нэмэгдэл	82,562,726.41	157,298,842.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,326,000.00	54,017,500.00
210104	Урамшуулал	25,849,770.99	20,879,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,000,100.00	61,745,353.80
210201	Тэтгэврийн даатгал	34,000,100.00	42,548,598.01
210202	Тэтгэмжийн даатгал	4,000,000.00	4,726,678.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,200,000.00	2,343,539.61
210204	Ажилгүйдлийн даатгал	800,000.00	2,343,539.61
210205	Эрүүл мэндийн даатгал	8,000,000.00	9,782,997.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,871,759.31	7,647,267.63
210301	Гэрэл, цахилгаан	5,125,100.00	4,398,217.63
210302	Түлш, халаалт	7,091,959.31	2,070,530.00
210303	Цэвэр, бохир ус	654,700.00	1,178,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	839,640.00	3,353,320.00
210401	Бичиг хэрэг	299,380.00	1,779,820.00
210402	Тээвэр, шатахуун	169,320.00	220,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	370,940.00	353,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	26,998,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	19,998,440.00
210604	Урсгал засвар	-	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	247,100.00	-
210702	Дотоод албан томилолт	247,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	372,952,079.40	1,009,682,757.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	367,479,819.40	1,008,189,656.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,650,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	47,180.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,280.00	49,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	703,800.00	1,340,146.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	429,168,228.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	429,168,228.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,986,464.13	100,323,796.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,184,000.00	57,032,754.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	54,761,254.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,184,000.00	2,271,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,802,464.13	43,291,042.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,802,464.13	43,291,042.68
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	118,555,829.92	0.00	478,667,088.17
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	118,555,829.92	0.00	478,667,088.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	65,681,516.87	0.00	65,681,516.87
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	400,238,530.25	0.00	400,238,530.25
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	584,475,877.04	0.00	944,587,135.29
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	574,392,690.64	0.00	934,503,948.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-12,810,975.59	0.00	-12,810,975.59
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	561,581,715.05	0.00	921,692,973.30
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	78,185,474.16	0.00	78,185,474.16
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,801,915.41	100,309,342.84	639,767,189.21	0.00	999,878,447.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,045,912,100.00	1,002,621,057.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,045,912,100.00	1,002,621,057.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	961,210,800.00	945,588,303.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,100,600.00	489,707,466.89
210101	Үндсэн цалин	288,992,900.00	275,964,974.61
210102	Нэмэгдэл	161,539,900.00	138,845,842.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,668,500.00	54,017,500.00
210104	Урамшуулал	28,899,300.00	20,879,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,887,300.00	59,408,928.80
210201	Тэтгэврийн даатгал	42,083,500.00	40,212,173.01
210202	Тэтгэмжийн даатгал	4,950,900.00	4,726,678.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,475,400.00	2,343,539.61
210204	Ажилгүйдлийн даатгал	2,475,500.00	2,343,539.61
210205	Эрүүл мэндийн даатгал	9,902,000.00	9,782,997.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,078,200.00	7,647,267.63
210301	Гэрэл, цахилгаан	5,792,700.00	4,398,217.63
210302	Түлш, халаалт	6,614,700.00	2,070,530.00
210303	Цэвэр, бохир ус	1,670,800.00	1,178,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,360,500.00	3,353,320.00
210401	Бичиг хэрэг	1,784,800.00	1,779,820.00
210402	Тээвэр, шатахуун	221,100.00	220,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	354,600.00	353,500.00

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,000,000.00	26,998,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,998,440.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	242,400.00	-
210702	Дотоод албан томилолт	242,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	359,541,800.00	358,472,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	357,757,800.00	356,979,779.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	145,400.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	84,300.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	49,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,600.00	22,000.00
210807	Газрын төлбөр	1,433,700.00	1,340,146.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,701,300.00	57,032,754.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,701,300.00	57,032,754.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,077,400.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	56,152,400.00	54,761,254.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,471,500.00	2,271,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,045,912,100.00	1,002,621,057.32
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,045,912,100.00	1,002,621,057.32
122005	Улсын төсвөөс санхүүжих	1,045,912,100.00	1,002,621,057.32
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	23.00
620001	Удирдах ажилтан	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	23.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	12.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,101,167,531.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,101,167,531.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,101,167,531.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,453,000.00
210102	Нэмэгдэл	18,453,000.00

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,336,425.00
210201	Тэтгэврийн даатгал	2,336,425.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	651,209,877.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	651,209,877.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,168,228.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	429,168,228.98
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,101,167,531.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,101,167,531.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	772,691,104.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	328,476,426.30
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,182.6 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулж санхүүгийн тайланд тусгав.

Аудитаар нийт 3,385.9 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрсэнд төлбөрийн акт тогтоов.

3.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдад албан томилолттой байх хугацаанд нь 375.0 мянган төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2024 оны А/292 болон аймгийн Засаг даргын 2024 оны Б/58 дугаартай захирамжаар үр дүнгийн 528.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөрийн үндсэн албан тушаалыг хавсран гүйцэтгүүлэх Б/33 дугаартай тушаал гаргаж 2024 оны 9, 10 дугаар саруудад үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдлийг хавсран гүйцэтгэсэн албан хаагчид 1,161.6 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-т “Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

албан үүргийнхээ зэрэгцээ түр орлох албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцна.”, 43.6-т “Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид 2024 оны 8-10 дугаар саруудад даргын албан тушаалын цалин олгож зөрүү 1,321.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.1-т “Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно.” гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

3.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын хөрөнгөнд бүртгэлгүй барилгын засварыг сайжруулалтаар бүртгэж тайлагнасан.	1	22,182.6	-	-	1	22,182.6	1	22,182.6	-	-	-	-
Дүн	1	22,182.6	-	-	1	22,182.6	1	22,182.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Томилолттой байх хугацаанд хоолны мөнгө давхардуулан олгосон	1	375.0	1	375.0	-	-	-	-	-	-	-	-
Урамшуулал давхардуулан авсан	1	528.0	1	528.0	-	-	-	-	-	-	-	-
Илүү нэмэгдэл олгосон	1	1,161.6	1	1,161.6	-	-	-	-	-	-	-	-
Цалин хөлсийг буруу тооцож олгосон	1	1,321.3	1	1,321.3	-	-	-	-	-	-	-	-
Дүн	4	3,385.9	4	3,385.9	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 26 ДДА-2025/140/НА-СГА-ТБЗ А1770309
Чойбалсан хот

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХГБХХЕГ-ын даргын 2024 оны Б/80 дугаартай тушаалаар Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг тусгасан байна. Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн цалинг ТЗ-4 шатлалаар буюу дэс түшмэлийн цалингийн шатлалаар цалинжуулсан байна. Мөн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөрийн үндсэн албан тушаал болон хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтнийг өөр албан хаагчаар хавсран гүйцэтгүүлэх Б/33 дугаартай тушаал гаргаж 40 хувийн нэмэгдэл олгож ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-т "Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ түр орлох албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцна.", 43.6-д "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

2125050084

1. Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөрт олгоогүй эрхийг хэрэгжүүлж өөрийн үндсэн албан тушаалыг хавсран гүйцэтгүүлэх тушаал гаргаж, нэмэгдэл олгосон, ХГБХХЕГ-ын даргын Б/80 дугаартай тушаалыг зөрчиж илүү авсан 2,482,860 /хоёр сая дөрвөн зуун наян хоёр мянга найман зуун жаран/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн хүү, торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Сайхангэрэл, нягтлан бодогч Ж.Тайвантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

М.УХААНБИЛЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 27 ДДА-2024/02/НА-СГА-7113 АМ70809
Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас албан томилолттой ажиллаж байгаа албан хаагчдад хоолны мөнгө давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," болон ЗГ-ын 2019 оны 06 дугаар тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ." гэсний 2.2.3-т "хоолны зардал." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон," гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан томилолттой байх хугацаанд давхардуулан олгосон хоолны мөнгө болох 375,000 /Гурван зуун далан таван мянга/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Сайхангэрэл, нягтлан бодогч Ж.Тайвантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



И.СЭМЖИДМАА
М.УХААНБИЛЭГ

2125050086



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 28 ДДА-2025/АУДИТ-ТА-ТЦЗ Чойбалсан хот АИ70309

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид ХГБХХЕГ-ын даргын 2024 оны А/292 дугаартай тушаал болон аймгийн Засаг даргын 2024 оны Б/58 дугаартай захирамжаар 2024 оны дөрөвдүгээр улирлын урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон урамшууллын 528,000 /таван зуун хорин найман мянга/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн хүү, торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2125050075

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Сайхангэрэл, нягтлан бодогч Ж.Тайвантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



И.СЭМЖИДМАА
М.УХААНБИЛЭГ